



МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРТ ЗОХИЦУУЛАЛТЫН ТУРШИЛТЫН ОРЧНЫ ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОХ НЬ

Судалгааны тайлангийн
хураангуй

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Энэхүү тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ)-ийн “Азийн Тогтвортой Дэд Бүтцийн Хөтөлбөр”-ийн хүрээнд боловсруулсан ба Төв болон Зүүн Өмнөд Азийн орнуудад дэд бүтцийн төлөвлөлтийг Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулахад дэмжлэг үзүүлэх бүс нутгийн санаачилгын хүрээнд хийсэн болно.

Тайлангийн үндсэн зорилго нь Монгол Улсын эрчим хүчний салбарт зохицуулалтын туршилтын орчин (regulatory sandbox)-ыг нэвтрүүлэхэд шаардлагатай суурь ойлголтыг бататгах, олон улсын туршлагыг хууль эрх зүйн болон техникийн боломжийн талаар харьцуулсан судалгааг хийх юм. Мөн Монгол Улсын эрчим хүчний салбарт тулгамдаж буй техник, технологийн болон засаглал, хууль эрх зүйн орчны өнөөгийн нөхцөл байдлыг үнэлж, тэдгээрийг шийдвэрлэхэд зохицуулалтын туршилтын орчны тогтолцоог хэрхэн бүрдүүлэх замын зураглал, зөвлөмж боловсруулахад чиглэсэн.

СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, ХАМРАХ ХҮРЭЭ


Монгол Улсын эрчим хүчний салбар нь сүүлийн жилүүдэд бодлого, зохицуулалтын, санхүүгийн болон нийгмийн олон давхар хүндрэлтэй тулгарсаар байна. Салбарын үндсэн дэд бүтэц болох нүүрсэнд суурилсан дулаан, цахилгаан хосолсон станцууд нь эрчим хүчний үйлдвэрлэлийн 90 орчим хувийг бүрдүүлж, хүлэмжийн хийн ялгаруулалт ихтэй, нэгдсэн сүлжээний бүтэц зохион байгуулалтаас шалтгаалсан үр ашиггүй байдлыг бий болгосон байна. Үүнтэй зэрэгцэн одоогийн хууль эрх зүй, зохицуулалтын орчин нь төвлөрсөн, төр давамгайлсан системд зориулсан бүтэцтэй тул сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хуримтлуур, шинэ үйлчилгээний загваруудыг нэвтрүүлэхэд уян хатан бус, хязгаарлагдмал зохицуулалт давамгайлдаг.

Эрчим хүчний салбарт техник технологи, салбарын бүтэц, засаглал болон санхүү эдийн засаг, үнэ тарифын зохицуулалтын хувьд уялдаа холбоотой суурь шинэчлэлийг хийх хэрэгцээ шаардлага үүссэн. Салбарын бүтээгдэхүүн хоорондын татаас, улс төрийн хэт хамааралтай засаглалын бүтцээс үүдэлтэй өртгөөс доогуур үнэ тарифын зохицуулалтаас шалтгаалж олон жилийн хуримтлагдсан алдагдал бий болсон байна. Хэдийгээр бодит хэрэгцээнээс давсан шинэ эх үүсгүүр барих тусгай зөвшөөрлүүдийг олгож, худалдах, худалдан авах гэрээг байгуулсан боловч хувийн болон гадны хөрөнгө оруулагчдад тус салбарт итгэн хөрөнгө оруулалт хийх хангалттай итгэлийг бий болгох нөхцөл бүрдэхгүй байна.

Нөгөө талаас, эрчим хүчний хүртээмжийн тэгш байдал алдагдаж, алслагдсан бүс нутаг болон Улаанбаатар хотын бага орлоготой өрхүүд хүлэмжийн хийн ялгарал өндөртэй түлш хэрэглэсээр байгаа нь нийгмийн болон эрүүл мэндийн эрсдэлийг улам гүнзгийрүүлж, эдийн засагт болон байгаль орчинд сөрөг дам нөлөөг бий болгосоор байна.

Иймд тус салбар нь нүүрсэнд суурилсан төвлөрсөн тогтолцоо, хуучирсан дэд бүтэц, өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэглээ зэрэг олон талт сорилттой тулгарч байгаа тул зөвхөн техник, технологийн шинэчлэл хийхээс гадна эрчим хүчний шилжилтийг дэмжих институцийн чадавх, засаглал, бодлого болон зохицуулалтын орчныг шинэчлэх хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна.

Зураг 1. Судалгааны хамрах хүрээ, үр дүн



Зохицуулалтын туршилтын орчин нь системийг бүхлээр нь шууд шинэчлэх бус, харин тодорхой хүрээнд, тодорхой цаг хугацаанд, хяналттай нөхцөлд зохицуулалтын уян хатан байдлыг бий болгон шинэ шийдлүүдийг бодит орчинд турших боломж олгодог.

Энэ хүрээнд өртөгт суурилсан тарифын загвар, хувийн хэвшлийн оролцооны шинэ хэлбэрүүд, ухаалаг тоолуурын системд суурилсан ухаалаг сүлжээг бий болгох, эрчим хүчний хуримтлуур, төвлөрсөн бус үйлдвэрлэл, хэрэглээний удирдлагын шийдлүүдийг туршиж, бодит өгөгдөлд тулгуурласан шийдвэр гаргах боломж бүрдэнэ. Нэн ялангуяа тарифын шинэчлэл нь улс төрийн болон нийгмийн хувьд эмзэг хэвээр байгаа нөхцөлд зохицуулалтын туршилтууд нь эрчим хүч хэрэглэгчийн хэрэглээний зан төлөв, төлбөр төлөх чадвар, нийгмийн хүлээн зөвшөөрөх түвшинг бодитоор тодорхойлох замаар үе шаттай шинэчлэл хийх боломжийг нээдэг.

Мөн зохицуулалтын туршилтын орчин нь тусгайлсан дүрэм, эрсдэлийн зохицуулалт бүхий хамгаалагдсан орчин бүрдүүлснээр хувийн хөрөнгө оруулалтыг татах, шинэ санхүүгийн загваруудыг турших, улмаар салбарын санхүүгийн тогтвортой байдлыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. Үүний зэрэгцээ, нэмэлт үйлчилгээний зах зээл, чадлын зах зээл, гүйцэтгэлд суурилсан үйлчилгээний механизм зэрэг зах зээлийн шинэ элементүүдийг турших замаар ирээдүйн эрчим хүчний чөлөөт зах зээлд шилжих суурийг бүрдүүлэх юм.

Иймээс зохицуулалтын туршилтын орчин нь Монгол Улсын эрчим хүчний салбарт тулгарч буй институц, зохицуулалтын хөшүүн байдал, санхүүгийн хязгаарлалтыг даван туулах, бодит туршилт, нотолгоонд суурилсан шинэчлэлийн үндэс суурийг бүрдүүлэх, улмаар эрчим хүчний салбарын тогтолцоог илүү үр ашигтай, тогтвортой, уян хатан чиглэлд шилжүүлэх стратегийн ач холбогдолтой зохицуулалтын хэрэгсэл юм.

СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

Зохицуулалтын туршилтын орчны судалгаанд холимог судалгааны аргачлал ашигласан бөгөөд олон улсын туршлага, бодлогын баримт бичигт суурилсан харьцуулсан дүн шинжилгээ, кейс судалгааг хослуулсан. Мөн зохицуулалтын орчны саад, боломжийг тодорхойлохын тулд Монгол Улсын эрчим хүчний салбарын институцийн болон эрх зүйн хүрээний үнэлгээ хийж, оролцогч талуудын саналыг тусгахыг зорисон болно. Холимог судалгааны хандлага нь инновацийг дэмжих зохицуулалтын хэрэгслийн үр нөлөө, хэрэгжүүлэх боломжийг бодит нөхцөлд үнэлэхэд чиглэлээ.

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ТОГТОЛЦОО, СТРАТЕГИ

Монгол Улсын эрчим хүчний салбарын зохицуулалтын тогтолцоо нь төрийн төвлөрсөн удирдлагын бүтэцтэй бөгөөд бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах болон техникийн хяналт тавих чиг үүргүүд институц хооронд хуваарилагдсан байдаг. Эрчим хүчний яам нь салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын чиглэлийг тодорхойлдог бол Эрчим хүчний зохицуулах хороо нь тусгай зөвшөөрөл, үнэ тарифын зохицуулалт, зах зээлийн үйл ажиллагаа болон хэрэглэгчийн эрх ашгийг зохицуулах бие даасан зохицуулагчийн үүргийг хэрэгжүүлдэг.

Урт хугацааны хөгжлийн бодлого болон эрчим хүчний салбарын стратегийн баримт бичгүүдэд сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх, эрчим хүчний үр ашгийг сайжруулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилтуудыг тусгасан байдаг. Тухайлбал, “Алсын хараа–2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН)-ийн хүрээнд эрчим хүчний салбарын бүтцийг төрөлжүүлэх, цэвэр технологийн хэрэглээг өргөжүүлэх чиглэлээр зорилт дэвшүүлсэн.

Гэвч эдгээр зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зах зээлийн механизм, хөрөнгө оруулалтын таатай орчин, технологийн туршилт хийх зохицуулалтын боломж хангалтгүй хэвээр байна. Иймээс бодлогын зорилтуудыг практикт хэрэгжүүлэхийн тулд шинэ технологи, бизнесийн загварыг хяналттай нөхцөлд турших, үр дүнд үндэслэн зохицуулалтыг үе шаттай шинэчлэх шаардлагатай байна.

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

Судалгааны тайланд зохицуулалтын туршилтын орчны тогтолцооны хүрээнд шийдвэрлэх боломжтой дараах харилцан уялдаа бүхий долоон техникийн саад бэрхшээлийг тодорхойлсон.


1	<p>Нүүрсний эх үүсвэрийн давамгайл байдал ба үйл ажиллагааны уян хатан бус байдал: Өвлийн улиралд ДЦС-ууд дулааны эрчим хүчний хэрэглээг тасралтгүй хангах горимоор ажилладаг тул зарим тохиолдолд сэргээгдэх эрчим хүчний нийлүүлэлтийг хязгаарлах шаардлага үүсдэг.</p>
2	<p>Сэргээгдэх эрчим хүчний хязгаарлалт: Салхи, нарны суурилагдсан хүчин чадал нэмэгдэж байгаа ч системийн уян хатан байдал хангалтгүйгээс оргил бус цагуудад үйлдвэрлэлийг хязгаарлах шаардлагатай болдог.</p>
3	<p>Дамжуулах сүлжээний тасалдал: Тархалт ихтэй, найдвартай байдал хангалтгүй, хагас тусгаарлагдсан дөрвөн бүсийн сүлжээ нь бүс хоорондын цахилгаан дамжуулалт болон сэргээгдэх эх үүсвэрийн ашиглалтыг хязгаарладаг ба, дамжуулах шугамын алдагдал хэт өндөр байна.</p>
4	<p>Түгээх сүлжээний дэд бүтэц: Нэг чиглэлийн урсгалд зориулагдсан одоогийн сүлжээ нь тархмал үйлдвэрлэл, дээврийн нарны систем, орон нутгийн хэмжээний жижиг хуримтлууруудыг дэмжихэд саад учруулж байна.</p>
5	<p>Хуримтлуур ба уян хатан байдлын зах зээлийн дутагдал: Томоохон хэмжээний эрчим хүч хуримтлуулах систем, тэнцвэржүүлэх зах зээл, туслах үйлчилгээний зах зээл, чадлын зах зээлийн зохицуулалт хөгжөөгүй, хууль эрх зүйн суурь байхгүй нь сэргээгдэх эрчим хүчний төслүүдийн нэвтрэх дээд хязгаарыг тогтоож байна.</p>
6	<p>Дижитал системийн сул байдал: Ухаалаг тоолуурын нэвтрүүлэлт бага, нэгдсэн мэдээллийн платформ хөгжөөгүй, SCADA системийн хамрах хүрээ хязгаарлагдмал гэх мэт техникийн чадавх сул байгаа нь өгөгдөлд суурилсан системийн удирдлагыг сааруулж байна.</p>
7	<p>Эрчим хүчний хүртээмжийн тэгш бус байдал: Алслагдсан бүс нутаг, гэр хорооллын өрхүүд, бага орлоготой хүн ам одоогийн нүүрсэнд суурилсан системийн сөрөг нөлөөг илүү ихээр үүрч байна.</p>

Хүснэгт 1. МУ-ын Эрчим хүчний системийн бэрхшээлүүд, түүнийг шийдвэрлэх боломжит санал болгож буй туршилтын төслүүд






Системийн хязгаарлалт	Техникийн онцлог	Зохицуулалтын саад	Зохицуулалтын туршилтын жишээ	Хүлээж буй үр дүн
ДЦС-ийн уян хатан бус байдал	Дулааны эрчим хүчний горимыг хангахын тулд ДЦС-уудыг тулсан горимоор ачааллах шаардлагатай	Уян хатан, хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцсон үнэ тогтоох зохицуулалтыг хийдэггүй	Төвийн эрчим хүчний системд батарей хуримтлуур + СЭХ хосолсон туршилтын төсөл	Хуримтлуур нь СЭХ-ний хязгаарлалтыг бууруулах үр нөлөөг тодорхойлох боломжийг бүрдүүлнэ.
Хуримтлуурын эх үүсгүүрт хууль эрх зүйн тодорхойгүй байдал	Хуульд тодорхой зохицуулалтыг тусгаагүй.	Тариф, тусгай зөвшөөрөл тодорхойгүй	Хуримтлуурыг системийн биет хөрөнгө байдлаар авч үзэх	Нотолгоонд суурилсан хууль эрх зүйн суурийг бий болгоно.
Дамжуулах сүлжээний хэт ачаалал	Говийн бүс болон Төвийн эрчим хүчний системийн хоорондох дамжуулах чадлын хязгаарлалт	Зардлыг бүрэн нөхөх механизм сул байдлаас шалтгаалж урт хугацааны дамжуулах сүлжээний хөрөнгө оруулалтыг төлөвлөдөггүй.	Тодорхой бүс нутагт СЭХ + хуримтлуурын хосолсон технологиудыг туршиж дамжуулах сүлжээний үйл ажиллагааг дэмжих	Орон нутгийн эрчим хүчний найдвартай байдлын үр нөлөөг үнэлэх боломж бүрдэнэ.
Түгээх сүлжээний дэд бүтэц сул	Хүчдэлийн хэлбэлзэл, нэг чиглэлт цахилгааны урсгал	Тархмал эх үүсвэрийн зохицуулалтад зориулагдаагүй	Сум, орон нутгийн түвшинд СЭХ, хуримтлуур хосолсон мини сүлжээний туршилтын төслүүд	Тархмал эх үүсгүүрийн холболтын стандарт боловсруулах боломж бүрдэнэ.
Дулааны эрчим хүчний нүүрс давамгайлсан зохицуулалт	Халаалтын зуух давамгайлсан үйлдвэрлэл	Цахилгаанжуулалтаар халаалтыг дэмжих үнэ тарифын зохицуулалт сул	Гэр хорооллын цахилгаан халаалт (улирлын шинжтэй тарифын зохицуулалт)	Төлбөрийн чадвар ба ачааллын нөлөөг үнэлэх боломж бүрдэнэ.
Тэнцвэржүүлэх зах зээл байхгүй	Туслах үйлчилгээний зохицуулалт байхгүй	Зөвхөн төвлөрсөн диспетчерийн зохицуулалтад суурилсан	Уян хатан зах зээлийн үйлчилгээний түр туршилтыг хэрэгжүүлэх	Тэнцвэржүүлэх зах зээлийн загвар боловсруулах боломж бүрдэнэ.
Ухаалаг тоолуурын дутагдал	Хүчдэлийн түвшинд суурилсан тарифын зохицуулалтыг хийдэггүй	Хэрэглэгчийн оролцоо хангалтгүй	Ухаалаг тоолуур + хэрэглээ талын зохицуулалт	Хэрэглээ талын уян хатан байдлыг тооцоолох боломж бүрдэнэ.
Алслагдсан сумдын дизель хамаарал	Өндөр зардалтай, системээс тусгаарлагдсан	Тархмал худалдан авалтын механизмгүй	Сэргээгдэх эрчим хүчний мини грид концессийн төсөл	Эрчим хүчний зардлыг бууруулах, найдвартай байдлыг үнэлэх боломж бүрдэнэ.


<p>Эрчим хүчний хангамж, хүртээмж, жендерийн тэгш бус байдлыг бий болгож байна.</p>	<p>Эрчим хүчний бодлогын сөрөг нөлөөлөлд эмэгтэйчүүд илүү өртөх хандлагатай</p>	<p>Хүйсийн мэдрэмжтэй бодлого боловсруулалт дутмаг</p>	<p>Цэвэр халаалтын тогтолцоог бүрдүүлэх, үйлчилгээ, үнэ тариф, санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх</p>	<p>Эрчим хүчний салбарын бодлого зохицуулалтад нийгмийн болон жендерийн асуудлыг авч үзэх боломжийг нэвтрүүлнэ.</p>
	<p>Хөрөнгө оруулалтын эрсдэл</p>	<p>Зохицуулалтын тогтворгүй байдал</p>	<p>Сүлжээнд нийлүүлсэн эрчим хүчний төлбөрийг найдвартай авах эрсдэл өндөр, тодорхойгүй</p>	<p>Туршилтын орчинд мини грид төслүүдийг хэрэгжүүлж, урьдчилан тодорхойлсон төлбөрийн механизмийг бий болгох</p>

Зураг 2: Олон улсын кэйс судалгаа



Хүснэгт 2. Туршилтын орчинд хэрэгжүүлсэн төслүүд болон холбогдох эрх зүйн зохицуулалтын олон улсын кейс судалгаа

Улс	Он	Удирдах байгууллага	Хууль эрх зүйн суурь	Хэрэгжсэн төслүүд	Монголд Улсад хамаарах гол сургамж
 Их Британи	2017	Ofgem – (Office of Gas and Electricity Markets) Байгалийн хий болон цахилгааны зах зээлийг зохицуулах газар	Тусгай зөвшөөрлийн нөхцөл; салбарын код	P2P худалдаа, цагийн ялгаварт тариф (TOU), Уян хатан зах зээл	Тусгай хуульгүйгээр зохицуулагч удирдан хэрэгжүүлэх боломжтой; уян хатан, кэйс бүрээр нөхцөлийг тодорхойлох
 Австрали	2019–2022	Австралийн эрчим хүчний зохицуулагч (AER) Австралийн эрчим хүчний зах зээлийн хороо (AEMC) Австралийн сэргээгдэх эрчим хүчний агентлаг (ARENA)	Цахилгаан эрчим хүчний үндэсний дүрэм (NER) 8.15; зохицуулагчийн заавар	Тархмал үйлдвэрлэл, батареи хуримтлуур, динамик тариф, хэрэглэгчийн оролцоо, Виртуал пауэр плант (VPP)	Одоо байгаа хуульд нэмэлт өөрчлөлт оруулах; тодорхой хугацаатай туршилтын хөнгөлөлт үзүүлэх; ил тод бүртгэл, тайлагнал.
 Сингапур	2017	Эрчим хүчний зах зээлийн газар (EMA)	Бүтэцтэй зөвшөөрлийн тогтолцоо	P2P арилжаа, Цагийн ялгаварт тариф (TOU), уян хатан зах зээл, ухаалаг тоолуур	Дүрэмчилсэн, тогтвортой; хэрэглэгчийг хамгаалах арга хэмжээ өндөр; нэн тэргүүнд дижитал дэд бүтцийг хөгжүүлэх шаардлагатай.
 Япон	2018	Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрлэлийн яам (METI)	Анхан шатны хууль; Засгийн газрын тогтоол	IoT төхөөрөмж, LUUP e-scooter, 30+ төсөл	Зохицуулалтын уян хатан байдал + санхүүжилтийг хослуулах; шинжээчдийн оролцоо итгэлцэл нэмэгдүүлэх.
 Эстони	2019	Уур амьсгалын яам (MIC)	ЕХ-ны “Цэвэр эрчим хүч” багц; уян хатан зохицуулалт	Estfeed дата платформ, хуримтлуур, хэрэглээ талын удирдлага, эрчим хүчний бүлгүүд, ухаалаг сүлжээ	Дижитал дэд бүтэц ба өгөгдлийн засаглал суурь нөхцөл; тусгай хуулиар зохицуулах шаардлагагүй.

 Молдова	2024	Эрчим хүчний яам (МОЕ) + Эрчим хүчний зохицуулалтын үндэсний газар (ANRE)	225/2024 тоот хууль	V2G- Цахилгаан машинаас сүлжээнд цахилгаан нийлүүлэх төсөл, Ухаалаг тоолуурын төсөл	Тусгай хууль нь хамгийн өндөр эрх зүйн тодорхой байдлыг хангана; төвлөрсөн зохицуулалт; урт хугацааны (7+5 жил) туршилт
-----------------------------------------------------------------------------------------------------	------	---------------------------------------------------------------------------	---------------------	-------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН СУУРЬ МАШ ЧУХАЛ

Тодорхой хууль эрх зүйн мандаттай улс орнууд хөрөнгө оруулагчдын итгэлийг илүү татаж, зөвхөн захиргааны шийдвэрт тулгуурласан загвартай харьцуулахад хууль зүйн эрсдэл багатай байдаг.

ЗОХИЦУУЛАГЧИЙН БИЕ ДААСАН БАЙДАЛ

Зохицуулагч байгууллага (жишээ нь Австрали, Их Британи)-аар удирдуулсан зохицуулалтын туршилтын орчны тогтолцоо нь улс төрийн нөлөөлөл багатай, шийдвэр гаргалт илүү тогтвортой байдаг.

ХЭРЭГЛЭГЧИЙГ ХАМГААЛАХ

Амжилттай хэрэгжиж буй загварууд бүгд хэрэглэгчийн мэдээлэлд суурилсан шийдвэр, туршилтын орчинд үүссэн маргаан шийдвэрлэх механизмыг заавал тусгасан байдаг.

СУРАЛЦАХ ХЭРЭГСЭЛ

Зохицуулалтын туршилтын орчны тогтолцоо нь аливаа оролцогчид давуу эрх олгох механизм бус, харин шинэ технологи, бизнесийн загвар болон шийдлүүдийг бодит орчинд туршин, харилцан суралцах бодлогын хэрэгсэл.

САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ

Австрали улсад хэрэгжүүлдэг бүхий буцалтгүй тусламж, Япон Улсын баталгаатай санхүүжилт зэрэг туршлагауд нь хувийн хэвшлийн оролцоог илүү үр дүнтэй татдаг болохыг харуулж байна.

ДИЖИТАЛ ДЭД БҮТЭЦ

Ухаалаг тоолуур, мэдээллийн платформ, бодит цагийн хяналт зэрэг нь зохицуулалтын туршилтын орчныг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөл болох юм.

БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

ЗОХИЦУУЛАЛТЫН ТУРШИЛТЫН ОРЧНЫ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭХ САНАЛ БОЛГОЖ БУЙ ХУУЛЬ ЭРХ, ЗҮЙ ЗАСАГЛАЛЫН ХҮРЭЭ

Монгол Улсын эрчим хүчний салбарт зохицуулалтын туршилтын орчныг хэрэгжүүлэх хууль эрх зүйн болон институцийн тогтолцоог бүрдүүлэх хоёр үндсэн хувилбар байгаагаас Монголын нөхцөлд тохирох хувилбар нь Эрчим хүчний тухай анхдагч хуульд өөрчлөлт оруулж эрх зүйн суурийг бий болгох, түүн дээр үндэслэн хэрэгжилтийн нарийвчилсан журмыг дэд зохицуулалтаар тогтоох “хосолмол загвар” хамгийн тохиромжтой. Энэ нь хууль эрх зүйн баталгааг хангахын зэрэгцээ уян хатан, хурдан хэрэгжих боломжийг олгоно.

Хэрэгжилтийн хүрээнд шинэ байгууллага байгуулах бус, харин Эрчим хүчний яам болон Эрчим хүчний зохицуулах хорооны дотор зохицуулалтын туршилтын орчны үйл ажиллагааг хэрэгжүүлэх тусгай нэгжийг байгуулж, төслийн сонгон шалгаруулалт, хэрэгжилт, хяналт, оролцогч талуудын уялдаа холбоог зохицуулах нь зүйтэй. Үүний зэрэгцээ байгууллагын чадавхыг бэхжүүлэх, урьдчилсан зөвлөлдөх платформ, нээлттэй санал авах тогтолцоо, оролцогч талуудын хэлэлцүүлгийг хөгжүүлэх замаар чанартай инновацийн төслийн урсгалыг бий болгох шаардлагатай.

Зохицуулалтын туршилтын орчны тогтолцоог практикт хэрэгжүүлэхдээ эхний ээлжинд 5–10 туршилтын төсөл сонгон авч, эрчим хүч хадгалах технологи, ухаалаг сүлжээ, сэргээгдэх эрчим хүчний интеграци, тархмал болон сүлжээнээс тусгаарлагдсан шийдлүүд зэрэг тэргүүлэх чиглэлд турших нь зүйтэй. Эдгээр төслүүдийг нээлттэй, ил тод сонгон шалгаруулж, бодит цагийн хяналт, тогтмол тайлагнал, эрсдэлийн хяналтын механизмтайгаар хэрэгжүүлэх бөгөөд туршилтын явцад илэрсэн зохицуулалтын саад бэрхшээл, шийдлүүдийг бодлого боловсруулах үйл явцад эргэж тусгах “зохицуулалтын суралцах цикл”-ийг бүрдүүлнэ.

Санал болгож буй зохицуулалтын тогтолцооны үндсэн ойлголт

Зохицуулалтын туршилтын орчны тогтолцоо нь гурван харилцан холбоо бүхий түвшинд цогцоороо хэрэгжих боломжтой.

ЗАСАГЛАЛЫН ТҮВШИН

- Хууль эрх зүйн үндэс,
- Хэрэгжүүлэгч гол байгууллага
- Дэмжих байгууллагууд

ЗОХИЦУУЛАЛТЫН ТҮВШИН

- Зохицуулалтын тайлбар, зөвлөмж бүхий албан бичиг, чиглэл хүргүүлэх
- Тусгай зөвшөөрөл, үнэ тариф, диспетчерийн зохицуулалт, зах зээлд оролцох нөхцөлтэй холбоотой тодорхой шаардлагуудаас хугацаатай чөлөөлөх, түр журам мөрдөх
- Одоо мөрдөгдөж буй техникийн код, дүрэмтэй зөрчилдөх тохиолдолд туршилтын төсөлд зориулсан тусгай техникийн шаардлагыг мөрдүүлэх

СУРАЛЦАХ САЙЖРУУЛАХ ТҮВШИН

- Туршилтын төслүүдэд хяналт-шинжилгээ, тайлагнал, үнэлгээний тогтолцоог хэрэгжүүлэх
- Нууцлалд хамаарахгүй үр дүн, сургамжийг олон нийтэд ил тод нийтлэх
- Туршилтын үр дүнд үндэслэн дараах шийдвэрүүдийг албан ёсоор гаргах: өргөтгөн нэвтрүүлэх, нөхцөлд өөрчлөлт оруулах, туршилтыг зогсоох

ЗОХИЦУУЛАЛТЫН ТУРШИЛТЫН ОРЧНЫ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛҮҮДИЙН ЗАМЫН ЗУРАГЛАЛ

Энэхүү замын зураглалын үе шат бүр дараагийн шатанд шаардлагатай нотолгоо, дэд бүтэц, зохицуулалтын чадавхыг бүрдүүлнэ. Монгол Улс суурь уян хатан байдал болон зохицуулалтын суралцах тогтолцоог эхлээд бий болгохгүйгээр шууд бүрэн либералчилсан зах зээл рүү шилжих боломжгүй юм.

Хүснэгт 3. Зохицуулалтын туршилтын орчинд хэрэгжүүлэх төслүүдийн замын зураглал

Үе шат	Хугацаа	Хамрах хүрээ, чиглэл	Суурь нөхцлүүд
I ҮЕ ШАТ	2026-2027 Хүртээмж, Аюулгүй байдал, Эрчим хүчний шилжилт	<ul style="list-style-type: none"> Алслагдмал бүс нутгийн цахилгаан хангамж, мини грид сүлжээ Цэвэр халаалтын технологиуд (гэр хорооллын бүсэд) Системийн хэмжээний хуримтлуур (зах зээлийн болон зах зээлийн бус хэрэгцээнд) Зохицуулалтын туршилтын орчныг хэрэгжүүлэх тусгайлсан нэгж байгуулах, хууль эрхзүйн суурь бүрдүүлэх 	ЭХЯ-ЭХЗХ-ны хоёрдогч хууль эрх зүйн зохицуулалт буюу зохицуулалтын туршилтын орчны тогтолцоог бодитоор хэрэгжүүлэхэд шаардлагатай журам эсвэл дүрмээр зохицуулалтыг хэрэгжүүлнэ.
II ҮЕ ШАТ	2028-2029 Уян хатан байдал & Дижитал шилжилт	<ul style="list-style-type: none"> Хэрэглээ талын удирдлага Ухаалаг сүлжээ & Ухаалаг тоолуурын мониторинг EV цахилгаан машин & ухаалаг цэнэглэлтийн сүлжээ Нарийвчилсан ялгаварт тарифын туршилт 	I үе шатны дэд бүтцэд тулгуурлан – ухаалаг тоолуур, өгөгдлийн платформуудыг ашиглах суурь нөхцөл бүрдсэн байна.
III ҮЕ ШАТ	2030-2032 Зах зээлийн чөлөөлөлт & Инновац	<ul style="list-style-type: none"> 2 талт гэрээт зах зээл ба өдрийн өмнөх зах зээл Тогтворжуулах ба нэмэлт үйлчилгээний зах зээл P2P арилжаа, ногоон устөрөгчийн туршилт Инновацын шинэ бизнесийн загвар 	II үе шатны суурь нөхцөл дээр тулгуурлан –зах зээлийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг турших боломжтой дэд бүтэц бий болсон, зохицуулалтын чадавх сайжирсан байна.

ЗОХИЦУУЛАЛТЫН ТУРШИЛТЫН ОРЧНЫ ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОХ БЭЛТГЭЛ ҮЕ ШАТ

Хууль эрх зүйн суурийг бүрдүүлэх, Оролцогч талуудыг мэдээллээр хангах:

1

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг Эрчим хүчний яам (ЭХЯ), Эрчим хүчний зохицуулах хороо (ЭХЗХ), НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ) хамтран боловсруулж, зохицуулалтын туршилтын орчны тогтолцоог хэрэгжүүлэх, удирдах чиглэлээр эрх зүйн бүрэн эрхийг бий болгох шаардлагатай. Уг хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх зорилтот хугацаа нь 2026 оны IV улирал юм.

Хэрэгжүүлэх суурийг бэлдэнэ.

2

Зохицуулалтын туршилтын орчныг хэрэгжүүлэх байгууллага нь өөрийн эрх мэдлийн хүрээнд түр Туршилтын Орчны Нэгжийг (2–3 ажилтантай) байгуулна. Урьдчилсан өргөдлийг хүлээн авч эхэлнэ, захиргааны чадавхийг бэхжүүлж, хэрэгжилтийн зохицуулалтыг бэлтгэнэ.

Материал хүлээн авч, урьдчилсан үнэлгээг эхлүүлнэ.

3

2026–2027 он: Хуульд нэмэлт өөрчлөлт орох хүртэл Засгийн газрын тогтоол болон ЭХЗХ-ны зохицуулалтын хүрээнд алслагдсан бүс нутгийн эрчим хүчний хангамжийг сайжруулах, халаалтын хэрэгцээг цахилгаанжуулах, мини-сүлжээ I үе шатны туршилтын төслүүдийн материалуудыг хүлээн авч эхлүүлнэ.

Донор байгууллагуудаас чадавх бэхжүүлэх техникийн туслалцаа авах.

4

2026–2027 он: НҮБХХ, АХБ болон Дэлхийн Банкны санхүүжилт, техникийн туслалцааны хүрээнд I үе шатны санхүүжилтэд дэмжлэг авна. Стандарт туршилтын орчны төслийн гэрээ, эрсдэл хуваалцах загвар болон хэрэглэгчийг хамгаалах арга хэмжээний протоколуудыг боловсруулна.

Эхний хэрэгжсэн төслүүдийг үнэлэх, дараагийн зохицуулалт руу шилжүүлэх.

5

2027–2028 он: I үе шатны нотолгооны дараагаар шаардлагатай хоёрдогч зохицуулалтын хэрэгслүүдийг – туршилтын орчны журмын зохицуулалт, тарифын арга зүйн нэмэлт өөрчлөлт, хуримтлуурын ангиллын дүрэм гэх мэт байнгын зохицуулалтад оруулах шаардлагатай зохицуулалтуудыг үнэлж – шаардлагатай дүрэм, журам стандартыг боловсруулан батлах.

Тасралтгүй суралцах, өгөгдөл, нотолгоог бүрдүүлэх.

6

Бүх туршилтын орчны үр дүнг – амжилтгүй төслүүдийг оруулаад – нийтэд тайлагнах боломжтой жилийн тайлангуудад нийтэлнэ. ЭХЗХ нь туршилтын орчны мэдээллийг жил бүр Парламентад тайлагнаж, туршилтын дуусгавар болсноос хойш 12 сарын дотор зохицуулалтын тохируулгыг санал болгоно.

ЗОХИЦУУЛАЛТЫН ТУРШИЛТЫН ОРЧНЫ ТОГТОЛЦООГ БОДИТООР ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

ЗОХИЦУУЛАЛТЫН ТУРШИЛТЫН ОРЧНЫГ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ

№	Зарчим	Тайлбар
1	Хэрэглэгч болон системийг хамгаалах	<ul style="list-style-type: none"> • Тухайн бүс нутгийн хэрэглэгчдэд мэдэгдэж, зөвшөөрлийг авна. • Системийн аюулгүй байдал, найдвартай байдал, өгөгдлийн хамгаалалтын тооцооллыг гаргасан байна. • Эмзэг бүлгийн хэрэглэгчдэд нөлөөлөх нөлөөллийг тооцсон байна.
2	Эрсдэлийн үнэлгээнд тулгуурласан уян хатан зохицуулалт	<ul style="list-style-type: none"> • Зохицуулалтын чөлөөлөлт нь эрсдэлийн түвшинтэй пропорциональ байна. • Өндөр эрсдэлтэй төслүүдэд илүү хатуу хяналт тавина.
3	Тогтмол хяналт ба өгөгдөл цуглуулалт	<ul style="list-style-type: none"> • Зохицуулагч байгуулагын зүгээс идэвхтэй мониторинг хийж, бүтэцтэй өгөгдөл цуглуулна. • Улирлын болон жилийн тайланг нийтэд нээлттэй байлгана.
4	Хязгаарлагдмал хугацаа ба орчин	<ul style="list-style-type: none"> • 1-3 жилийн тодорхой хугацаанд хэрэгжүүлэх нөхцлийг тодорхойлж өгнө. • Хамрах хүрээ, ажиллагааны нөхцлийг урьдчилан тодорхойлно. • Туршилтын дараа шийдвэр гаргана.
5	Туршилтын орчноос гарах, цаашид өргөжих тодорхой арга зам	<ul style="list-style-type: none"> • Туршилтаас гарах замыг тодорхой тусгаж өгөх шаардлагатай. • Бүх үр дүнг бодлого боловсруулахад ашиглана.

Хүснэгт 4: Төсөл сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлтүүд

№	Шалгуур	Тайлбар
1	Инновацийн шаардлага	Одоо байгаа дүрэм журамд зохицуулалт нь ороогүй, шинэлэг техник, технологи, бүтээгдэхүүн, үйлчилгээ эсвэл төлбөрийн загвар байх
2	Зохицуулалтын саадыг тодорхойлох	Ямар тодорхой дүрэм, зохицуулалт нь туршилтад саад болж байгааг тодорхойлсон байх
3	Нийгмийн үр ашиг	Иргэд, хэрэглэгч, орон нутагт, системийн үйл ажиллагаанд ашиг тус нь тодорхой байх
4	Эдийн засгийн үр ашиг	Зардал-үр ашгийн шинжилгээ болон хөрөнгө оруулалтыг нөхөх, санхүүжүүлэх механизм тодорхой байх
5	Туршилтын төлөвлөгөө	Үе шаттай, цаг хугацааны хувьд тодорхой туршилтын төлөвлөгөө байх
6	KPI үзүүлэлт	Журамд заасан үндсэн гүйцэтгэлийн үзүүлэлтүүд (ҮГҮ) тодорхой, хэмжигдэхүйц боломжийг бүрдүүлсэн байх
7	Эрсдэлийг бууруулах арга хэмжээ	Боломжит эрсдэл, сааруулах арга хэмжээг тодорхойлсон байх
8	Техникийн чадавх	Туршилтыг хэрэгжүүлэх техникийн чадавх, хүний нөөц, дэд бүтэцтэй байх
9	Санхүүгийн чадавх	Туршилтын хугацаанд санхүүгийн тогтвортой байдал нотлогдсон байх
10	Ёс зүй	Хэрэглэгч, нийгэм, эрчим хүчний системд хохирол учруулахгүй, ёс зүйн зарчмуудад тодорхойлсон байх

Хамгаалалт ба хяналт-шинжилгээний тогтолцоо

Зохицуулалтын туршилтын орчин нь уян хатан зохицуулалт олгодог ч хэрэглэгчийн эрх, системийн найдвартай байдал, санхүү болон өгөгдлийн аюулгүй байдлыг хамгаалах эрсдэлд суурилсан хамгаалалтын тогтолцоонд заавал үйл ажиллагаа явуулах ёстой. Үүнд:

- **Хэрэглэгчийг хамгаалах:** сайн дурын оролцоо, ил тод мэдээлэл, тарифын хамгаалалт, эмзэг хэрэглэгчдэд тусгайлан анхаарах
- **Системийн найдвартай байдал:** Сүлжээний стандарт мөрдөх, дамжуулах болон түгээх сүлжээ, системийн оператортой нягт уялдаатай ажиллах, үйл ажиллагааны хязгаар, онцгой үед зогсоох механизм
- **Санхүүгийн эрсдэлийн удирдлага:** Хэрэглэгч, төр, компаниудын эрсдэлийн хязгаар, зардал нөхөх тодорхой механизм, хамтын санхүүжилт
- **Өгөгдлийн хамгаалалт:** Нууцлал, цахим аюулгүй байдал, өгөгдлийн эзэмшил ба ашиглалтын тодорхой журам

Бүх төслүүд нь KPI-д суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний системд хамрагдаж, техникийн, эдийн засгийн, байгаль орчны, хэрэглэгчийн болон дижитал гүйцэтгэлийн үзүүлэлтээр үнэлэгдэнэ.

Үндсэн гүйцэтгэлийн үзүүлэлтийн ангилал (KPI)

Sandbox төслүүдийн гүйцэтгэлийг үнэлэхдээ дараах үндсэн үзүүлэлтүүдийн ангиллыг багтаана:

- **Техникийн гүйцэтгэл** (жишээ нь: найдвартай ажиллагааны сайжралт, сэргээгдэх эрчим хүчний интеграц, уян хатан байдлын хувь нэмэр)
- **Эдийн засгийн гүйцэтгэл** (жишээ нь: зардлын үр ашиг, системийн зардлын бууралт, тарифт үзүүлэх нөлөө)
- **Байгаль орчны гүйцэтгэл** (жишээ нь: хүлэмжийн хийн ялгарлын бууралт, нүүрс эсвэл дизелийн орлуулалт)
- **Хэрэглэгчид үзүүлэх нөлөө** (жишээ нь: төлбөрийн боломж, үйлчилгээний чанар, оролцооны түвшин)
- **Дижитал болон өгөгдлийн гүйцэтгэл** (жишээ нь: өгөгдлийн хүртээмж, ухаалаг систем, платформын ажиллагаа)

Төслүүд нь тогтмол (жишээлбэл, улирал тутам) тайлан гаргах бөгөөд эцсийн үнэлгээний тайланг мөн ирүүлнэ. Бүх хугацаанд Зохицуулалтын туршилтын орчны тогтолцоог хэрэгжүүлэх нэгж тасралтгүй хяналт тавина.

Гарах хувилбар ба шийдвэр гаргах тогтолцоо

Зохицуулалтын туршилтын хугацаа дуусахад хариуцсан нэгж нь KPI үзүүлэлтүүдийн үр дүн, оролцогч талуудын санал, системд үзүүлсэн нөлөөнд үндэслэн тохирох гарах хувилбарыг тодорхойлно. Шийдвэр гаргах үйл явц нь ил тод, нотолгоонд суурилсан, урт хугацааны зохицуулалтын зорилготой нийцсэн байх ёстой.


Дараах гурван үндсэн хувилбар байна:

- **Өргөжүүлэх (зохицуулалтад нэвтрүүлэх)** Төсөл тодорхой үр ашиг үзүүлж, эрсдэл нь удирдах боломжтой тохиолдолд хэрэглэнэ. Үүний үр дүнд зохицуулалтын өөрчлөлт, шинэ дүрэм журам, эсвэл зах зээлийн өргөн хүрээнд нэвтрүүлэх үйл ажиллагааг эхлүүлнэ.
- **Өөрчлөх эсвэл сунгах.** Үр дүн эерэг боловч нэмэлт баталгаажуулалт, сайжруулалт шаардлагатай үед хэрэглэнэ. Шинэчилсэн нөхцөл, хамрах хүрээтэйгээр туршилтыг үргэлжлүүлэх боломж олгоно.
- **Зогсоох.** Төсөл KPI үзүүлэлтүүдийг хангахгүй эсвэл хүлээн зөвшөөрөх боломжгүй эрсдэл үүсгэсэн тохиолдолд хэрэглэнэ. Зохицуулалтын хөнгөлөлтүүдийг цуцалж, туршилтыг дуусгавар болгоно.

Үр дүнгээс үл хамааран бүх туршилтын төслүүд нь сургамж, дүгнэлтүүдийг баримтжуулах, зохицуулалтын сайн болон сул талыг тодорхойлох, цаашдын бодлого болон хууль эрх зүйн шинэчлэлд санал боловсруулах зэрэг бүтэцтэй суралцах, эргэх холбооны үйл явцад заавал хувь нэмэр оруулах ёстой. Ингэснээр түр туршилт нь олон улсын шилдэг туршлагад нийцсэн, нотолгоонд суурилсан зохицуулалтын хөгжлийг дэмжих нөхцөлийг бүрдүүлэх юм.

ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ПРОЦЕСС

Зураг 3. Зохицуулалтын туршилтын орчинд төсөл хэрэгжүүлэх процессийн зураглал



Хүснэгт 4. Зохицуулалтын туршилтын орчинд төсөл хэрэгжих процесс

<p>1. ӨРГӨДӨЛ ГАРГАХ (Apply):</p>	<p>ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ</p> <p>Өргөдөл гаргагч нь зорилго, инновацийн шийдэл, тулгарч буй зохицуулалтын саад, туршилтын аргачлал, KPI, эрсдэлийн төлөвлөгөө, хэрэглэгчийн хамгаалалт, санхүүгийн үндэслэл болон шаардлагатай хөнгөлөлтүүдийг багтаасан бүрэн саналын багцыг Зохицуулалтын туршилтын орчны тогтолцоог хэрэгжүүлэх Туршилтын орчны нэгжид ирүүлнэ.</p>
<p>2. АНХАН ШАТНЫ ҮНЭЛГЭЭ (Screen):</p>	<p>ЗОХИЦУУЛАЛТЫН ТУРШИЛТЫН ОРЧНЫ ТОГТОЛЦООГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУРШИЛТЫН ОРЧНЫ НЭГЖ</p> <p>Зохицуулалтын туршилтын орчны тогтолцоог хэрэгжүүлэх Туршилтын орчны нэгж 20 ажлын хоногт багтаан баримт бичгийн бүрдэл болон урьдчилсан үнэлгээ хийж, шаардлагатай тохиолдолд нэмэлт мэдээлэл шаардана.</p>
<p>3. ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ (Approve):</p>	<p>ЗОХИЦУУЛАЛТЫН ТУРШИЛТЫН ОРЧНЫ ТОГТОЛЦООГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ</p> <p>Зохицуулалтын туршилтын орчны тогтолцоог хэрэгжүүлэх нэгж нь туршилтыг албан ёсоор баталж, олгогдох хөнгөлөлт, хугацаа, хамрах хүрээ, хэрэглэгчийн хамгаалалт, хяналт-шинжилгээ, тайлагнал, гарах нөхцөлийг тодорхойлсон шийдвэр гаргана.</p>
<p>4. Туршилт хэрэгжүүлэх (Test):</p>	<p>ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ ТУРШИЛТЫН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ</p> <p>Өргөдөл гаргагч туршилтын төслийг хэрэгжүүлж, Зохицуулалтын туршилтын орчны тогтолцоог хэрэгжүүлэх нэгж болон холбогдох байгууллагууд хамтран хяналт тавина. Улирал тутам тайлагнаж, эрсдэл үүсвэл нөхцөлийг өөрчлөх боломжтой.</p>
<p>5. ҮНЭЛГЭЭ (Evaluate):</p>	<p>ТУРШИЛТЫН ТӨГСГӨЛД</p> <p>Туршилтын төгсгөлд өргөдөл гаргагч эцсийн тайлан гаргаж, Зохицуулалтын туршилтын орчны тогтолцоог хэрэгжүүлэх нэгж нь 60 хоногийн дотор бие даасан үнэлгээ хийж, бүх үр дүнг ил тод нийтэлнэ.</p>
<p>6. ГАРАХ ШАТ (Exit):</p>	<p>ГУРВАН ХУВИЛБАР</p> <p>Туршилтын дараах гурван хувилбар байна:</p> <ul style="list-style-type: none"> (a) байнгын зохицуулалтад шилжүүлэн өргөжүүлэх, (b) нэмэлт туршилтад сунгах, (c) төслийг зогсоох. <p>Бүх үр дүн салбарын бодлого, дүрэм шинэчлэлд шууд тусгагдана.</p>

ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ҮЗҮҮЛЭХ ҮР АШИГ



Эрчим хүчний системд үзүүлэх нөлөө

- Нүүрсний хамаарлыг үе шаттайгаар бууруулах
- Сэргээгдэх эрчим хүчийг системд нэгтгэх баталгаажсан загварууд бий болгох
- Системийн уян хатан байдал, тэсвэрлэх чадварыг сайжруулах
- Цэвэр халаалтын шийдлүүд нэвтрүүлж, агаарын чанарт шууд эерэг нөлөө үзүүлэх
- Зах зээлийн байнгын шинэчлэл хийхэд шаардлагатай нотолгооны суурийг бүрдүүлэх



Хэрэглэгчид болон нийгэмд үзүүлэх үр нөлөө

- Хөдөө орон нутагт найдвартай, боломжийн үнэтэй цахилгаан хангамж
- Хотын агаарын чанар сайжрах – ялангуяа гэр хорооллын өрхүүдэд
- Тарифын ил тод байдал, хариуцлага нэмэгдэх
- Шинэ эрчим хүчний үйлчилгээ, оролцооны боломжууд бий болох
- Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН) болон Тогтвортой хөгжлийн зорилт 7-д хувь нэмэр оруулах



Хөрөнгө оруулагчид болон инновац бүтээгчдэд

- Зах зээлд нэвтрэхэд шаардлагатай хууль эрх зүйн тодорхой байдал
- Анхдагч хөрөнгө оруулагчдын эрсдэлийг бууруулсан орчин
- Төслийн түвшний орлогын бүтэц болон гарах (exit) тодорхой механизм
- Олон улсын ногоон санхүүжилтийн хэрэгслүүдэд нэвтрэх боломж
- Цаашид өргөжүүлж, байнгын зах зээлд шилжих суурь туршлага (track record) бүрдүүлэх



Зохицуулагч байгууллагад

- Байгууллагын чадавх, мэргэжлийн чадамж бэхжих
- Дүрэм, журам боловсруулахад нотолгоонд суурилсан үндэс бүрдэх
- Хөрөнгө оруулагчид болон оролцогч талуудын итгэл нэмэгдэх
- Тарифын шийдвэрт үзүүлэх улс төрийн дарамт буурах
- Олон улсын зохицуулалтын стандарттай нийцэх боломж нэмэгдэх

ДҮГНЭЛТ

Монгол Улсын эрчим хүчний шилжилт нь сэргээгдэх нөөц, технологи, эсвэл олон улсын дэмжлэг дутсанаас бус харин төвлөрсөн, нүүрсэд суурилсан, төр давамгайлсан хуучин зохицуулалтын хүрээнд хязгаарлагдаж байна. Энэхүү тогтолцоо нь өөрийн анхны зорилгыг хангалттай биелүүлдэг боловч өнөөгийн шаардлагад нийцсэн, төвлөрсөн бус, өгөгдөлд суурилсан, олон хөрөнгө оруулагч оролцсон, хэрэглэгч төвтэй эрчим хүчний системийг дэмжих боломжгүй.

Зохицуулалтын туршилтын орчин нь эдгээр асуудлыг бүрэн шийдэх хэрэгсэл биш бөгөөд тарифын гажуудлыг шууд засах, институцийн давхардлыг арилгах, эсвэл дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг бүрэн шийдвэрлэх боломжгүй. Харин энэ нь бодит нөхцөлд инновацийн шийдлүүдийг турших, нотолгоо бий болгох, улмаар тогтолцооны шинэчлэлийг шат дараатай хэрэгжүүлэх боломж олгодог цорын ганц бодит хэрэгсэл юм.

Тайлангийн дүн шинжилгээ нь энэхүү аргачлал Монголд хэрэгжих бүрэн боломжтойг, дотоодын хууль эрх зүйн орчинд суурь боломж байгааг, мөн олон улсын туршлагаар баталгаажсан болохыг харуулж байна. Энэхүү туршилтын орчны механизмийг удирдан үйл ажиллагааг явуулах тохиромжит байгууллага нь Эрчим хүчний зохицуулах хороо хэмээн үзэж байгаа бөгөөд Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах замаар хууль эрх зүйн үндсийг бүрдүүлж, салбарын тулгамдаж буй асуудлуудыг үе шаттай шийдвэрлэх замын зураглал боловсруулах нь оновчтой арга зам юм.

Зохицуулалтын туршилтын орчны тогтолцоо нь системийн шинэчлэл хийх бэлтгэл суурь болох бөгөөд шатлалтай, үр ашигтай, зах зээлд суурилсан эрчим хүчний шилжилтийг дэмжих “зохицуулалтын хэрэгсэл” болно.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

AER	Австралийн Эрчим Хүчний Зохицуулагч
ЭХЗХ	Эрчим Хүчний Зохицуулах Хороо (МУ)
ARENA	Австралийн Сэргээгдэх Эрчим Хүчний Агентлаг
ҮТХН	Үндэсний Тодорхойлсон Хувь Нэмэр
ТЭХС	Төвийн Эрчим Хүчний Систем (МУ)
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
ДЦС	Дулаан Цахилгааны Станц
SIPA	Азийн Тогтвортой Дэд Бүтцийн Хөтөлбөр
ЗТО	Зохицуулалтын Туршилтын Орчин
ЕМА	Эрчим Хүчний Зах Зээлийн Байгууллага (Сингапур)
СЗХ	Санхүүгийн Зохицуулах Хороо (МУ)
V2G	Тээврийн хэрэгсэл-Сүлжээ
Ofgem	Хий болон Цахилгааны Зах зээлийн Газар (Их Британи улс)
GCF	Ногоон Уур Амьсгалын Сан
ЭХЯ	Эрчим Хүчний Яам
ТХЗ	Тогтвортой Хөгжлийн Зорилго
OECD	Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Байгууллага
P2P	Хэрэглэгч-Хэрэглэгч харилцаа

ЕРӨНХИЙ МЭДЭГДЭЛ

Энэхүү судалгааны тайлангийн хураангуйг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ)-ийн “Азийн Тогтвортой Дэд Бүтцийн Хөтөлбөр”-ийн хүрээнд боловсруулав. Тайлангийн агуулга зөвхөн зөвлөмжийн шинж чанартай бөгөөд МУ-ын Засгийн газар, Эрчим хүчний яам болон НҮБХХ-ийн албан ёсны бодлого, байр суурийг шууд илэрхийлээгүй. Энэхүү тайланд ашигласан мэдээллийн үнэн зөв эсэх, тухайн материалыг ашигласны улмаас гарах үр дагаварт НҮБХХ болон хамтран хэвлүүлэгч байгууллага хариуцлага хүлээхгүй болно. Тус баримт бичигт тодорхой нутаг дэвсгэр, газарзүйн бүсийг нэрлэхдээ “улс” гэсэн нэр томъёог ашигласан нь ямарваа нэгэн газар нутгийн эрх зүйн болон бусад статусын талаарх үзэл бодол, утга агуулгыг илэрхийлээгүй болно.